

## АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

### I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ.

#### Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

**Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:**

**Дагаж мөрдөх огноо:**

#### Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

2023.12.27

#### Байгууллагын нэр:

Цагдаагийн ерөнхий газар

#### Нэгжийн нэр:

Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага

#### Албан тушаалтны нэр:

Баг, хороо хариуцсан цагдаа

#### Албан тушаалын ангилал, зэрэглэл:

ТТ-9

#### Ажлын цаг:

8 цаг

#### Ажлын байрны албан ёсны нэршил:

Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын байр

#### Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

#### Онцгой нөхцөл:

Байгалийн гамшиг, гол түймэр, хүн, малын гоц халдварт өвчин гарсан, гэнэтийн болон бусад аюул тохиолдсон, нийтийн эмх замбараагүй байдал үүссэн, террорист халдлага, онц болон дайны байдал зарласан, онц ноцтой гэмт хэрэг үйлдэгдсэн зэрэг зайлшгүй тохиолдолд өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллах.

### II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ.

#### Албан тушаалын зорилго:

Хариуцсан нутаг дэвсгэрт гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүргийн хүрээнд нийтээр дагаж мөрдөх дүрэм журмыг сахиулах, хяналт тавих, үйл ажиллагааг зохион байгуулах, удирдлагаас өгсөн үүрэг, ажлын чиглэлийг хэрэгжүүлэхээр зохион байгуулалтын арга хэмжээ авах.

#### Албан тушаалын зорилт:

- Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хариуцсан нутаг дэвсгэрт зохион байгуулахад оролцох, үр дүнг тайлагнах, цаашид хэрэгжүүлэх асуудлын саналыг танилцуулах.
- Хариуцсан ажлын чиг үүргийн хүрээнд алба хаагчдын мэдлэг, ур чадварын түвшинг дээшлүүлхэд анхаарах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, сурган дадлагажуулах, хяналт тавих, илэрсэн зөрчлийг шууд удирдах даргад танилцуулах.
- Хууль тогтоомж, дүрэм журмаар хүлээлгэсэн ажлын байрны зорилгод нийцсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах-Т, Хариуцан Гүйцэтгэх-Г, Хянах-Х, Шийдвэрлэх-Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	<p>1.1. Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах, үр дүнг тайлагнах;</p> <p>1.2. Хууль тогтоомж, дээд шатны байгууллага, албан тушаалтан удирдлагаас гаргасан шийдвэр, үүрэг, ажлын чиглэл, албан даалгавар, заавар, зөвлөмж, хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх, цагдаагийн бусад алба хаагч, нэгжтэй хамтран ажиллах;</p> <p>1.3. Нийтийн хэв журам хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, зөрчил шалгаж шийдвэрлэх, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хараа хяналтгүй болсон хүүхэд, гээгдэл эд хөрөнгө, алдуул малыг бүртгэх түүнтэй холбоотой асуудлыг шийдвэрлэх, эрх бүхий байгууллага, албан тушаалтны даалгасан сураггүй алга болсон хүнийг эрэн сурвалжлах дээрх чиглэлээр гарсан хууль, дүрмийн хэрэгжилтийг хангаж ажиллах;</p> <p>1.4. Галт зэвсэг, гэрээт харуул хамгаалалт, тэсэрч дэлбэрэх болон химийн хортой бодисын тухай хуулийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;</p> <p>1.5. Архидан согтуурахтай тэмцэх, гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах ажилд оролцож үр дүнг танилцуулах;</p> <p>1.6. Иргэд, байгууллагаас ирүүлсэн гомдол, мэдээллийг хүлээн авах, хойшлуулшгүй ажиллагаа явуулах, хариуцсан нутаг дэвсгэрт үйлдэгдсэн зөрчлийг шалгах;</p> <p>1.7. Хариуцсан нутаг дэвсгэрт хорио цээр, хязгаарлалтын дэглэм сахиулах, нийтийн эмх замбараагүй байдал үссэн, террорист халдлага гарсан, Онц болон дайны байдал зарласан үед олон нийтийн аюулгүй байдлыг хангах, жагсаал, цуглааныг албадан тараах ажиллагаа, нийтийг хамарсан арга хэмжээний үеийн хамгаалалтад ажиллах, удирдлагыг мэдээ, мэдээллээр хангах, өгсөн үүргийг хэрэгжүүлэх, үр дүнг танилцуулах.</p>	Цагдаагийн байгууллагын техникийн шуурхай бэлэн байдал хангагдана.	Г Г Г Г Г Г Т Т Г

	<p>2.1.Гэмт хэрэг, зөрчлийн статистик мэдээнд дүн шинжилгээ хийж, урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний саналыг боловсруулж, нутгийн захиргааны байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран ажиллах.</p> <p>2.2.Олон нийтийн цагдаагийн ажилтнуудыг өдөр тутмын мэргэжлийн удирдлагаар хангаж танилцуулах;</p> <p>2.3.Нутаг дэвсгэрийн хэмжээнд хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр гудамж талбай, олон нийтийн газар, аж ахуйн нэгж, байгууллагуудыг камержуулах ажлыг зохион байгуулах, мэдэгдэл, шаардлага, зөвлөмж тараах;</p> <p>2.4.Олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийн хүрээнд нийтийн эмх замбараагүй байдал, жагсаал цуглаан, террорист халдлага гарсан, онц болон дайны байдал зарласан, үйлдвэрлэлийн осол, гол түймэр, байгалийн гамшиг, хүн, малын гоц халдварт өвчин үүссэн. гэнэтийн бусад аюул тохиолдсон үед хорио цээр, хязгаарлалтын дэглэмийг сахиулах, нийтийг хамарсан арга хэмжээний үеийн хамгаалалтад ажиллах;</p> <p>2.5.Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх, эрх бүхий байгууллага, албан тушаалтны даалгаснаар сураггүй алга болсон хүн, гээгдэл эд хөрөнгийг эрэн сурвалжлах;</p> <p>2.6.Үйл ажиллагаандaa цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмыг мөрдөх, судлах, ажлын хариуцлага, сахилга ёс зүйг сахиж, өөрийнхөө мэдлэг, боловсрол, гоо зүй, бие бялдраа хөгжүүлэх, харилцааны соёл, албан үүрэг гүйцэтгэх чадвараа байнга дээшлүүлэх.</p>	Г Г Т Албаны бэлэн байдал хангагдана. Г Т Г
3 дугаар зорилтын хүрээнд	<p><b>Ажлын байрны зорилгын хүрээнд явуулах бусад үйл ажиллагаа:</b></p> <p>1.Хууль тогтоомж, дүрэм, журмаар хүлээлгэсэн ажлын байрны зорилгод нийцсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.</p> <p>2.Шууд удирдах албан тушаалтнаас өгсөн хууль ёсны үүрэг даалгаврын биелэлтийг хангах</p> <p>3. Албан хэрэг хөтлөлт, архивын журмыг өдөр тутмын үйл ажиллагаандaa мөрдөх ажиллах</p> <p>4.Төрийн алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлж, байгууллагын ажилтнууд болон харилцагч, үйлчлүүлэгчид иргэдтэй зөв боловсон харьцах ёс зүйн зөрчил дутагдал гаргахгүй байх</p>	Г Г Г Г

	<p><b>Шударга ёсны шалгуурыг хангах, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх талаар:</b></p> <p>1. Авлига, хүнд суртлаас ангид байж хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн, шударга ёсыг эрхэмлэн “Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг чанд сахих;</p> <p>2. Явцuu эрх ашиг сонирхлоос татгалзаж, цагдаагийн байгууллага, албаны нийтлэг эрх ашиг сонирхлыг эрхэмлэн ажиллах.</p>		Г
--	---	--	---

### III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

<b>Боловсрол</b>	Бүрэн дунд ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй.		
<b>Мэргэжил</b>			
<b>Мэргэшил</b>	Цагдаагийн мэргэжил олгох сургалтад хамрагдаж, төгссөн байх		
<b>Туршлага</b>			
<b>Ур чадвар</b>	Дүн шинжилгээ хийх	Албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдэээлэл цуглуулах. Гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах.	
	Асуудал шийдвэрлэх	- Байгууллагын чиг үүргийн хэрэгжилтэд өөрийн ажил үүргийн оруулах хувь нэмэр, оролцог ойлгодог. - Өөрийн үйл ажиллагааны үр дунд хяналт тавьж чаддаг.	
	Багаар Ажиллах	- Өөрийн мэдлэг ур чадвар, өөрт байгаа мэдлэгийг баг хамт олонтойгоо хуваалцаж хамтран ажиллах. - Багийн хүрээнд өөрт ногдсон үүргээ гүйцэтгэх.	
	Бусад		

### IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

<b>Албан тушаалтыг шууд харьялан удирдах албан тушаалын нэр:</b> Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах тасгийн дарга	
<b>Албан тушаалтыг шууд харьялан удирдах албан тушаалын нэр, тоо:</b>  Батлагдсан орон тоо	<b>Бусад харилцах субъект:</b>  <b>Шууд харилцах:</b> Хариуцсан асуудлаар бусад яам, агентлагийн албан тушаалын адил болон түүнээс доош зэрэглэлтэй албан тушаалтан.  <b>Шууд бус харилцах:</b> Төрийн бус байгууллага, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, олон улсын байгууллага /Эдгээртэй харилцахдаа Цагдаагийн албаны тухай хууль, бусад хууль тогтоомж, үйл ажиллагааны журмын холбогдох заалтыг баримтална/.

**V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ**

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:
Албан тушаал: ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭД ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА  T.ГАНЗОРИГ  2023 оны 12 дугаар сарын 27-ны өдөр	Байгууллагын нэр:..... Шийдвэрийн огноо:..... Дугаар:.....
<b>Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:</b> <u>Байгууллагын нэр: ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР</u> Шийдвэрийн огноо: 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдөр. Дугаар: <u>Я/ЧО1</u>  ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА  T.СУХБОЛД  2023 оны 12 дугаар сарын 27-ны өдөр	

**Танилцсан:**

Танилцсан албан тушаалтан: ..... .....
20... оны .... дугаар сарын ....-ны өдөр